

Ном хэвлэлийн ажил, номын худалдааны талаар
БНАГУ-ын Соёлын Яам, БНМАУ-ын Соёлын Яамны
хооронд 1974-1976 онд хамтран ажиллах
протокол

БНАГУ-ын Соёлын Яам, БНМАУ-ын Соёлын Яамны төлөөлөгчид
ном хэвлэл, номын худалдааны талаар хамтран ажиллах хэлэлцээг
1974 оны II сарын 29 -нд Берлин хотноо хийж тохиролцов.

Хэлэлцэгч талууд 1972 оны 8-р сарын 8-нд Улаанбаатар
хотноо гарын үсэг зурсан ном хэвлэлийн ажил ба номын худал-
дааны талаархи хамтын ажиллагааны протокол хэрэгжин биелэсэн
үр дүнг хэлэлцээд уул баримт бичигт тавьсан зорилт биелэгджээ
гэсэн дүгнэлт санал нэгтэй хийв.

Ялангуяа БНАГУ-ын 25 жилийн ой, БНМАУ-ыг тунхагласны 50
жилийн ой болон олон улсын номын жилтэй холбогдуулан авч
явуулсан арга хэмжээ онцгой ач холбогдолтой боллоо.

БНАГУ, БНМАУ-ын хооронд соёл шинжлэх ухааны талаархи хамтын
ажиллагааны төлөвлөгөө болон социалист орнуудын ном хэв-
лэлийн удирдах байгууллагуудын төлөөлөгчдийн Варшавын
зөвлөлгөөнөөс гаргасан зөвлөмжийн дагуу хэлэлцэгч этгээдүүд
хамтын ажиллагаагаа цаашид хөгжүүлэх эрмэлзлэлээр удирдлага
болгон ном зохиолыг хэвлэж тараан дэлгэрүүлэх ажлыг улам
гүнзгийрүүлж хөгжүүлэх зорилгоор 1974-1976 онд дор дурдсан
арга хэмжээг биелүүлэхээр тохиролцов. Үүнд:

I. Хэвлэлийн газар, номын худалдааны хамтын ажиллагаа

I. Нийгэм, эдийн засаг, улс төр, шинжлэх ухааны бүх салбарын



талаархи хамгийн чухал номыг харилцан орчуулах буюу хэвлэх Үүний зэрэгцээ тус хоёр орны социалист бүтээн байгуулалтын ололт амжилт, ирээдүйн төлвийг сурталчилах болон хөрөнгөтний үзэл суртал, маоизм, империализм, ревизионизм, шинэ колоничлолын бодлогын эсрэг чиглэгдсэн ном хэвлэх явдлыг онцлон үзнэ.

2. Хоёр орны зохиолчдын шилдэг бүтээлийг харилцан орчуулж хэвлэх.

3. Толь бичиг, дүрслэх урлагийн бүтээлийг хэвлэх /дахин хэвлэх/ талаар хамтран ажиллах.

4. Хоёр тал орчуулахаар санал болгож буй номын жагсаалт танилцуулгыг орос хэлээр солилцож байх. Харилцан орчуулах ном нь ЗХУ-д орос хэлээр орчуулагдаж гарсан бол нэрсийн жагсаалтыг хоёр тал жилд нэг удаа орос хэлээр солилцож байх.

5. Ном хэвлэлийн талаар хоёр орны амьдралд болж буй тэмдэглэлт ой, үйл явдалтай холбогдсон арга хэмжээ хурал зөвлөлгөөн үзэсгэлэн зэрэгт төлөөлөгчөө харилцан урих.

6. Харилцан орчуулах номын эхийг бэлтгэх болон үндэснийхээ хэлээр эхий нь бэлтгэсэн номыг хэвлэх явдлыг харилцан дэмжинэ.

7. Хоёр орны хэвлэлийн газрууд харилцан орчуулсан ном хэвлэлээ солилцож байна.

8. Ижил төрлийн хэвлэлийн газруудын хооронд шууд харилцаа тогтоон түүнийг цаашид гүнзгийрүүлэх явдлыг дэмжинэ.

9. Хоёр тал сэдэвчилсэн төлөвлөгөө, каталог зэрэг мэдээллийн материалыг байнга солилцож байна.

10. Хэлэлцэгч талууд өөрсдийн орны холбогдолтой ном хэвлэлийг

аль болох өргөн хэвлэхийг харилцан дэмжинэ.

11. Хоёр орны номын худалдааны байгууллага тус тусынхаа ном, тогтмол хэвлэл, хэвлэлийн бусад бүтээгдэхүүнийг харилцан худалдаалах ажлыг улам эрчимжүүлж, арга хэлбэрийг баяжуулна. Үүний тулд мэдээлэл харилцан байнга солилцож байна.

12. БНАГУ-ын Соёлын Яам ном хэвлэл, хэвлэлийн үйлдвэрлэл, номын худалдааны талаар өөрийн оронд гарч буй "Берсенблатт", "Друк унд папийр" сэтгүүлээс тус бүр нэг хувийг БНМАУ-ын Хэвлэлийн газарт тогтмол явуулж байна.

13. Ном хэвлэл, номын худалдааны ажлын талаар гарсан зохион байгуулалтын өөрчлөлтийг харилцан мэдээлж байна.

14. БНМАУ БНАГУ-д жил бүр явагддаг "Дэлхийн сайхан ном"-ын үзэсгэлэнд тогтмол оролцож байна.

15. БНМАУ-ын Соёлын Яам БНАГУ-ын Соёлын Яамны урилгыг хүлээн авч Лейпциг хотноо 1977 онд зохиогдох Олон улсын номын урлагийн үзэсгэлэн /ИБА/-д оролцно. Уг үзэсгэлэнгийн Олон улсын бэлтгэл хороонд идэвхитэй оролцож ажиллана.

II. Мэрэгжилтэн солилцох талаар

Хэвлэлийн эх бэлтгэл, номын худалдааны талаар гарч буй тэргүүн туршлага, шинэ ололтыг нэвтрүүлэх зорилгоор хоёр тал доор дурьдсан арга хэмжээг авах, үүнд:

1. БНАГУ-ын Соёлын Яам жил бүрийн Лейпцигийн хаврын ярмаркийн үеэр монгол ном сурталчилах булан гаргаж БНМАУ-ын төлөөлөгч хоёр хүнийг урин оролцуулж байхаас гадна ном хэвлэлийн эх бэлтгэл, номын худалдааны талаар харилцан туршлага солилцохоор хэлэлцэгч тал тус бүр хоёр хүнийг хорин хоногийн хугацаагаар солилцно.

2. Хэлэлцэгч талууд жил бүрийн шилдэг номынхоо үзэсгэлэнгийн журиг харилцан нэг нэг төлөөлөгчөө оролцуулж байна.



3. Хэрвээ мэрэгжилтэн солилцох шаардлагатай гэж үзвэл хоёр тал саналаа солилцож, томилолтын зорилт, ажиллагааны хөтөлбөр, хугацааг урьдчилан тогтсоны дараа тус бүрийн удирдах байгууллагуудад тавьж шийдвэрлүүлж байна.

Жич: хэлэлцэгч талууд номын худалдааны хамтын ажиллагааны тухай асуудлыг боловсруулж БНМАУ, БНАГУ-ын эдийн засгийн хамтарсан комиссын хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Энэхүү протоколд заасан хамтын ажиллагааныхаа дүнг гаргах харилцан мэдээлэл солилцож шинэ зорилтоо тодорхойлохын тул 1976 оны III улиралд БНМАУ-ын тал БНАГУ-ын Соёлын Яамны хоёр төлөөлөгчийг хүлээн авч хамтын ажиллагааны шинэ протоколд гарын үсэг зурна.

Уул протокол нь хоёр улсын соёлоор харилцах төлөвлөгөөний салшгүй хэсэг мөн.


Энэхүү протоколыг 1974 оны арван нэгдүгээр сарын 29-нд Берлин хотноо монгол герман хэлээр үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эдгээр хувь тус бүр адил хүчин төгөлдөр болно.

Эл протокол 1976 оны 12-р сарын 31-нийг хүртэл хүчин төгөлдөр байх болно.

БНМАУ-ын Соёлын Яамны
эрх олгосноор


Нэгдүгээр орлогч сайд

БНАГУ-ын Соёлын Яамны
эрх олгосноор


Орлогч сайд